Байгууллагын нэр: **“УЛААНБААТАР ЛИФТ” НӨҮГ**

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

2022 оны 12 дугаар сарын 23 Улаанбаатар хот

| Шийдвэрийн дэс дугаар | Зүйл, заалтын дэс дугаар | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга | Хэрэгжилтийн явц | Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасулах тухай санал) | Тасарсан болон удааширч байгаа шалтгаан |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| Салбар чиглэл: 1 | | | | | |
| 1.1. Монгол Улсын хууль | | | | | |
| 1.2. Улсын Их Хурлын тогтоол | | | | | |
| 1.3. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол | | | | | |
| 1.4. Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | |
| 1.5. Засгийн газрын тогтоол | | | | | |
| 1 | 1 | “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдөр, Дугаар 258 | Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдуулан байгууллагад сахилга, дэг журам, дотоод хяналтыг чангатгах, хууль тогтоомж, дүрэм, журмыг чанд сахих, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн (erp.ulaanbaatar.mn цахим хуудас болон цаасаар) өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэж байх, ажилчдын цаг ашиглалтыг хурууны хээний хяналтын системээр байнга бүртгэж, түүнд тавих хяналтыг сайжруулах, ажлын цагийг бүрэн, үр дүнтэй ашиглах, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох зэрэг ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна. Түүнчлэн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн сайжруулж | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар болон галт, хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг хориглосон заалтуудыг нэмж тусган хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд нийт ажилтнуудад дахин танилцуулж, үүрэг даалгавар өгч гарын үсэг зуруулж, баталгаажуулан ажилласан. | | |
| 2 | 1 | "Журам шинэчлэн батлах тухай" 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр, Дугаар 1 | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" 1 дүгээр тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдуулан "Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтын түвшинд үндэслэн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журам"-ыг хэрэгжүүлж халдвараас сэргийлэх дэглэмийг сахиж, дархлаажуулалтад нийт ажилтнуудыг хамруулсан. | 100% | |
| 3 | 5.4, 5.5 | "Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр, Дугаар 7 | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн "Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 7 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдуулан байгууллагын нийт албан хаагчдын монгол хэл үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээг авч, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлж, байгууллагын өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж хэвшүүлсэн. | 100% | |
| 1.6. Ерөнхий сайдын захирамж | | | | | |
| 1.7. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | | | | |
| 1.8. Улсын онцгой комиссын хурлын тэмдэглэл | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | 1.3 | Улсын онцгой комиссын хурлын тэмдэглэл, 2022.01.10-ны өдрийн 01 дүгээр тэмдэглэл | Улсын онцгой комиссын 01 дүгээр хурлаар Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтын нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээ, төлөвлөгөө, урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах төсвийг авч хэлэлцсэнтэй холбогдуулан гаргасан хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийг хангах зорилгоор манай байгууллагын үйл ажиллагаатай холбоотой дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан. Үүнд:<br><br>- Халдвар хамгаалал, хорио цээр, хязгаарлалтын дэглэмийг баримтлан, үйл ажиллагаагаа тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж ажилласан. Захирамж, шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд халдвар хамгаалал, хорио цээр, хязгаарлалтын дэглэмийг баримтлан, үйл ажиллагаагаа тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Ковид-19-ийн тархалтаас урьдчилан сэргийлж, олноор нэг дор бөөгнөрөхгүй байх, хоорондын зай барих зэргээр халдвар хамгааллын дэглэмийг баримтлуулж ажилтан, албан хаагчдыг цахимаар болон зайнаас ажиллуулсан.<br>Ажилтнуудын гарыг ариутгах, амны хаалтыг тогтмол хэрэглүүлэн /Ажилтан бүрт 1 удаагийн маск 100 ширхэгийг олгосон. Гар ариутгагч, 1 удаагийн бээлий, ажлын хувцсаар өдөр тутам хангаж ажилласан болно./<br>- Ажлын байранд агааржуулалтыг 2 цаг тутамд, байгууллагын дотор орчинд цэвэрлэгээг, Жавелионы /хлорамин/ уусмалаар байгууллагын өрөөнүүд, хаалганы бариул, ширээ, цонхны тавцанг арчих, ариутгал, халдваргүйжүүлэлтийг өдөр бүр хуваарийн дагуу тогтмол хийж гүйцэтгэсэн. | | |
| 5 | 1.3 | Улсын онцгой комиссын шуурхай ажлын хэсгийн хурлын тэмдэглэл, 2022.01.14-ний өдөр | Улсын онцгой комиссын шуурхай ажлын хэсгийн хурлаар Коронавируст халдвар (Ковид-19)-ын нөхцөл байдал, хариу арга хэмжээний талаар авч хэлэлцсэнтэй холбогдуулан гаргасан хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийг хангах зорилгоор манай байгууллагад ажиллаж байгаа бага насны хүүхэдтэй /0-5 насны/ 2 | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | ажилтныг нэг сарын хугацаанд цахимаар ажиллуулж, халдварын эрсдэлээс хамгаалсан. | | |
| 1.10. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол | | | | | |
| 1.11. Нийслэлийн Засаг даргын захирамж | | | | | |
| 6 | 1, 3 | "Хотын иргэний жил" болгон зарлах тухай 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр, Дугаар А/01 | Нийслэлийн Засаг даргын 2022 оны "2022 оныг Хотын иргэний жил" болгон зарлах тухай" 01 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдуулан дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:<br>- Байгууллагуудын нэгжүүдээс санал авч нэгтгэн 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдөр НЗДТГ-т хүргүүлсэн.<br>- Иргэдэд цахилгаан шатаар аюулгүй зорчих талаар анхан шатны мэдлэг олгох, сурталчлах эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэрээт лифтүүдийн тоог нэмэгдүүлж орлогоо нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна.<br>Үүнд:<br>-Иргэдэд цахилгаан шатаар аюулгүй зорчих анхан шатны ойлголт өгөх ажлын хүрээнд гэрээт ААНБ, СӨХ-ны удирдлагуудтай уулзах, хяналт шалгалт хийх, ЛТААД-ийг таниулах гаргасан хуваарийн дагуу БГД, СХД-ийн лифт ашиглагч болон эзэмшигч байгууллагуудын удирдлагуудтай 2022 оны 03 сарын 15-наас 23-ны өдрүүдэд, 04 дүгээр сарын 14-нөөс 25-ны өдрүүдэд биечлэн уулзаж арга зүйн зөвлөгөө мэдээлэл өгсөн. Мөн лифтээр зорчих үеийн аюулгүй ажиллагааны санамж боловсруулж СӨХ-дэд 2022 оны 02 дугаар сард хүргүүлсэн. "Улаанбаатар лифт" НӨҮГ-ын өөрийн сайт болон фейсбүүк хуудсанд байнга байршуулан нийтэд сурталчилж байна. Аюулгүйн санамжуудыг Нийслэлийн 4 байршилд байгаа явган хүний гүүрэн гарцнуудын 8 лифтэнд байршуулсан. Мөн цахилгаан шатаар зорчих үедээ иргэдтэй байнга харилцаж цахилгаан шаттай хэрхэн харилцах, хэрхэн ашиглах талаар заавар зөвлөгөөг тогтмол өгч ажиллаж байна.<br>-2022 онд "Баян төгөл" СӨХ 1 лифт, "Өргөө 144" СӨХ-ны 3 лифт, "Чандмана" СӨХ-ны 3 лифт, "Чинван" СӨХ-ны 1 лифт, "Гандирс" СӨХ-ны 1 лифт, "Оргил-8" СӨХ-ны 7 лифт, "Арт" СӨХ-ны 3 лифт, "G-108" СӨХ-ны 1 лифт, "Улсын хоёрдугаар төв эмнэлэг"-ийн 2 лифт, "Бэрс 2" СӨХ-ны 4 лифт, нийт 26 лифтэнд шинээр засвар, | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | техник үйлчилгээ хийж гүйцэтгэх ажлын гэрээ байгуулж, 67 ААНБ, СӨХ-дын 360 ширхэг лифтэнд техникийн ээлжит магадлал хийсэн. | | |
| 7 | 1.1, 1.6, 1.8 | "Хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх тухай" 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдөр, Дугаар А/212 | Нийслэлийн Засаг даргын "Хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх тухай" 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/212 дугаар захирамжийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдуулан дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:<br>- Хөрөнгө оруулалтаар 2021-2022 он дамжин хэрэгжсэн 8 цахилгаан шатны шинэчлэлийн ажил бүрэн хэрэгжиж дууссан бөгөөд улсын комисст хүлээлгэн өгч, цахилгаан шатуудыг байнгын ашиглалтад оруулсан.<br>Нийслэл, нийслэлийн орон нутгийн сангийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжиж буй нийтийн зориулалттай орон сууцны барилгын 20 цахилгаан шатны шинэчлэлийн ажил хэрэгжиж байна. Тус 20 цахилгаан шат шинэчлэлийн ажлаас нийтийн зориулалттай орон сууцны барилгын ашиглалтын шаардлага хангахгүй 1 цахилгаан шатыг шинэчлэх ажлын бэлтгэл хангагдсан байна.<br>Мөн 19 цахилгаан шатны шинэчлэлийн ажлын гүйцэтгэгч байгууллага шалгарсан бөгөөд "Фүшили элеватор" ХХК 4 цахилгаан шат, "Төвхөн трейд" ХХК 5 цахилгаан шат, "Оакс экспресс монголиа" ХХК 10 цахилгаан шатны шинэчлэлийн ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. Ажил гүйцэтгэх гэрээний дагуу тус 19 цахилгаан шатыг БНХАУ-ын үйлдвэрлэгч компани руу захиалга хийгдсэн бөгөөд 2 цахилгаан шатны тээвэрлэлт хийгдэж, 17 цахилгаан шат үйлдвэрлэгдэх шатандаа явж байна.<br>Монгол Улсын Засгийн Газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн Газрын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд "Улаанбаатар хотын нийтийн зориулалттай орон сууцны 139 цахилгаан шатыг шинэчлэх төсөл"-ийг шинэчлэн боловсруулж, УБЗАА-нд хүргүүлсэн. Төслийн хүрээнд шинэчлэгдэх ашиглалтын хугацаа нь дууссан 139 лифтний хонгилын хэмжилт хийх ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 01-13-ны өдрүүдэд Беларусь Улсын "Могилевлифтмаш" ХК-ийн инженер техникийн ажилчид болон "Улаанбаатар Лифт" НӨҮГ-ын инженер техникийн ажилчид хамтран гүйцэтгэсэн. Дээрх төслийн зээлийн эргэн төлөлт нь тодорхойгүй, цаг үеийн нөхцөл байдал (дайны нөхцөл)-аас шалтгаалан хэрэгжих нь тодорхойгүй болсон тул нийслэлийн 2022 | 80% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | оны төсвийн "Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэх их засварын төсөл, арга хэмжээний жагсаалт"-ын 24.1.10-т батлагдсан "Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат шинэчлэлт" төсөл, арга хэмжээний 1,301,000.0 (нэг тэрбум гурван зуун нэг сая) төгрөгөөр ашиглалтын хугацаа дууссан нэн түрүүнд яаралтай шинэчлэх шаардлагатай 10 цахилгаан шатыг шинэчлэн солих саналыг 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 216 дугаартай албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн бөгөөд тус саналын дагуу 10 цахилгаан шат шинэчлэгдэж байна. | | |
| 8 | 2 | "Эрх шилжүүлэх тухай" 2022 оны 02 сарын 17-ны өдөр, Дугаар А/209 | Нийслэлийн Засаг даргын "Эрх шилжүүлэх тухай" 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/209 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдуулан цаашид хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг захиалагчийн хяналт тавих эрх шилжсэн байгууллагууд хянан баталгаажуулахад холбогдох хууль, журам болон захирамжийн хэрэгжилтийг хангаж ажилласан. | 100% | |
| 9 | 1 | "Төсвийн хуваарь батлах тухай" 2022 оны 01 сарын 17-ны өдөр, Дугаар А/22 | Нийслэлийн Засаг даргын "Төсвийн хуваарь батлах тухай" 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/22 дугаар захирамжийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдуулан 2022 оны нийслэлийн төсвийн орлогын сар, улирлын хуваарийг батлагдсан, оны эхнээс төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг жигд хангаж, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд гэрээт ААНБ, СӨХ-дын тоог нэмэгдүүлж техник үйлчилгээнээс орох орлогыг өсгөх, техникийн ээлжит магадлалыг өнгөрсөн оныхоос нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна.<br>-2022 онд "Баян төгөл" СӨХ 1 лифт, "Өргөө 144" СӨХ-ны 3 лифт, "Чандмана" СӨХ-ны 3 лифт, "Чинван" СӨХ-ны 1 лифт, "Гандирс" СӨХ-ны 1 лифт, "Оргил-8" СӨХ-ны 7 лифт, "Арт" СӨХ-ны 3 лифт, "G-108" СӨХ-ны 1 лифт, "Улсын хоёрдугаар төв эмнэлэг"-ийн 2 лифт, "Бэрс 2" СӨХ-ны 4 лифт, нийт 26 лифтэнд шинээр засвар, техник үйлчилгээ хийж гүйцэтгэх ажлын гэрээ байгуулж, 67 ААНБ, СӨХ-дын 360 ширхэг лифтэнд техникийн ээлжит магадлал хийсэн. | 100% | |
| 10 | 2, 4 | "Хуулийн хэрэгжилтийг хангах тухай" 2021 оны 10 сарын 22-ны өдөр, Дугаар А/828 | - Нийслэлийн Засаг даргын "Хуулийн хэрэгжилтийг хангах тухай" 2021 оны А/828 дугаар захирамжийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдуулан Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Засаг | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга, эдгээр хуулийг дагалдан гарсан хууль тогтоомжийн шинэлэг зохицуулалтыг байгууллагын ажилтнууд болон иргэдэд сурталчлан таниулах, хуулийг дагаж мөрдөх бэлтгэл ажлыг хангах үүднээс 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр сургалт зохион байгуулж ажиллалаа. Мөн байгууллагын цахим хуудаст байршуулан сурталчилж байна.<br>- Нийслэл хотын дүрэмд оруулах саналаа 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдөр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлсэн болно. | | |
| 11 | 2, 4 | "Ажлын хэсэг байгуулах тухай" 2022 оны 04 сарын 27-ны өдөр, Дугаар А/578 | - Нийслэлийн Засаг даргын "Ажлын хэсэг байгуулах тухай" 2022 оны А/578 дугаар захирамжийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдуулан Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг үндэслэн байгууллагын даргын 2022 оны 04 дүгээр сарын 29–ний өдрийн А/20 тушаалаар биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийг устгах устгах комисс байгуулан биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийг цуглуулахад үндэслэл болгосон дүрэм, журмыг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуультай нийцүүлэх ажлыг зохион байгуулж, тайлан мэдээг хүргэсэн. | 100% | |
| 12 | 1, 2 | "Хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай" 2022 оны 05 сарын 16-ны өдөр, Дугаар А/656 | - Нийслэлийн Засаг даргын "Хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай" 2022 оны А/656 дугаар захирамжийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдуулан манай байгууллагад тэргүүн дэд, дэд, орлогч дарга ажиллаагүй болно. Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгоогүй бөгөөд орон тоог хэвээр хадгалаагүй болно. Санхүүгийн сахилга батыг мөрдөн ажиллах хүрээнд цахилгааны зардлаас 200,071.41 төгрөг, түлш халаалтын зардлаас 321,726.94 төгрөг, цэвэр бохир усны зардлаас 834,304.30 төгрөгийг тус тус хэмнэсэн. Шуудан холбоо интернэтийн зардлаас 442,088.32 төгрөг хэмнэсэн. Байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан батлагдсан цалинг олгож ажилласан. | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 13 | 1, 2 | “Хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” 2022 оны 05 сарын 16-ны өдөр, Дугаар А/657 | - Нийслэлийн Засаг даргын "Хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай" 2022 оны А/657 дугаар захирамжийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдуулан манай байгууллагад тэргүүн дэд, дэд, орлогч дарга ажиллаагүй болно. Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгоогүй бөгөөд орон тоог хэвээр хадгалаагүй болно. Санхүүгийн сахилга батыг мөрдөн ажиллах хүрээнд цахилгааны зардлаас 200,071.41 төгрөг, түлш халаалтын зардлаас 321,726.94 төгрөг, цэвэр бохир усны зардлаас 834,304.30 төгрөгийг тус тус хэмнэсэн. Шуудан холбоо интернетийн зардлаас 442,088.32 төгрөг хэмнэсэн. Байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан батлагдсан цалинг олгосон. | 100% | |
| 14 | 1 | “Хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” 2022 оны 06 сарын 09-ний өдөр, Дугаар А/789 | Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу байгууллагын дарга Д.Ган-Эрдэний албан хэрэгцээнд унаж байсан 64-09 УНР улсын дугаартай автомашины мэдээллийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлж, авто баазад хүлээлгэн өгсөн. Үүний үр дүнд тээвэр шатахууны зардлаас 273,645.00 төгрөг, гаражийн түрээсийн зардлаас 224,000.00 төгрөгийг тус тус хэмнэсэн. | 100% | |
| 15 | 2 | “Нийслэлийн 2021-2022 оны өвөлжилтийн дүн, 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах тухай” 2022 оны 06 сарын 24-ний өдөр, Дугаар А/853 | Нийслэлийн 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлыг хангах хүрээнд нийт 5 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан.<br>-Хөрөнгө оруулалтаар 2021-2022 он дамжин хэрэгжсэн 8 цахилгаан шатны шинэчлэлийн ажил бүрэн хэрэгжиж дууссан бөгөөд улсын комисст хүлээлгэн өгч, цахилгаан шатуудыг байнгын ашиглалтад оруулсан.<br>-Нийслэл, нийслэлийн орон нутгийн сангийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжиж буй нийтийн зориулалттай орон сууцны барилгын 20 цахилгаан шатны шинэчлэлийн ажил хэрэгжиж байна. Тус 20 цахилгаан шат шинэчлэлийн ажлаас нийтийн зориулалттай орон сууцны барилгын ашиглалтын шаардлага хангахгүй 1 цахилгаан шатыг шинэчлэх ажлын бэлтгэл хангагдсан байна.<br>Мөн 19 цахилгаан шатны шинэчлэлийн ажлын гүйцэтгэгч байгууллага шалгарсан бөгөөд “Фушили элеватор” ХХК 4 | 93% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | цахилгаан шат, “Төвхөн трейд” ХХК 5 цахилгаан шат, “Оакс экспресс монголиа” ХХК 10 цахилгаан шатны шинэчлэлийн ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. Ажил гүйцэтгэх гэрээний дагуу тус 19 цахилгаан шатыг БНХАУ-ын үйлдвэрлэгч компани руу захиалга хийгдсэн бөгөөд 2 цахилгаан шатны тээвэрлэлт хийгдэж, 17 цахилгаан шат үйлдвэрлэгдэх шатандаа явж байна.<br>-Хамтран ажилладаг гэрээт 52 ААНБ, СӨХ-дын 146 лифтэнд сар бүр засвар,техник үйлчилгээг хийж өвлийн улиралд хэвийн ажиллах нөхцэл боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.<br>-Гүүрэн гарцуудад суурилуулсан 8ш цахилгаан шатны засвар, техник үйлчилгээг сар бүр хийж хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажиллаж байна.<br>-Гэрээгээр хамтран ажилладаг ААНБ, СӨХ-дын хүсэлт болон МХЕГ-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд лифт ашиглагч байгууллагын хүсэлтийн дагуу нийт 67 ААНБ, СӨХ-дын 360 лифтэнд техникийн ээлжит магадлалыг хийж гүйцэтгэсэн. | | |
| 16 | 1 | “Журам шинэчлэн батлах тухай” 2022 оны 08 сарын 23-ны өдөр, Дугаар А/1106 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх шинэчлэн батлагдсан журмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. | 100% | |
| 17 | 2.6 | “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 2022 оны 10 сарын 21-ний өдөр, Дугаар А/1357 | СХД-ийн 34-р хорооны сайжруулсан шахмал түлшийг хэрэглэх заавар зөвлөгөө, сэрэмжлүүлгийг тогтмол өгч, айл өрх бүрийн зуух яндангийн битүүмжлэл, аюулгүй байдлыг хангуулж, түүхий нүүрс хэрэглүүлэхгүй байх чиглэлээр хяналтын үйл ажиллагааг эрчимжүүлэн мэдээг 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн өдөр бүр Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтэст хүргүүлэн ажилласан. | 100% | |
| 18 | 1 | “Байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх тухай” 2022 оны 12 сарын 01-ний өдөр, Дугаар А/1504 | “Байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх тухай” 2022 оны А/1504 дүгээр захирамжийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр манай байгууллагын үр дүнг үнэлж, хангалттай үнэлгээ авсан. | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1.12. Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэл | | | | | |
| 19 | 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.5, 1.6, 1.7 | Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, 2022.01.21-ний өдрийн 01 дүгээр тэмдэглэл | Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 01 дүгээр хуралдаанаар иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2021 оны жилийн эцсийн тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан гаргасан хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийг хангах зорилгоор манай байгууллагын үйл ажиллагаатай холбоотой дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:<br>- Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийг хангах зорилгоор манай байгууллагын үйл ажиллагаатай холбоотой дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан. Үүнд:<br>- 2022 оны жилийн эцсийн байдлаар иргэдээс манай байгууллага, албан тушаалтанд гаргасан 18 өргөдөл, гомдол, санал хүсэлтийг бүх талаас нь нягтлан судалж, хууль зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэж, хуулийн хугацаанд иргэнд хариу өгч ажилласан.<br>- Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хийх дүн шинжилгээг сайжруулан, өргөдөл, гомдлын шалтгаан нөхцлийг байгууллагын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн нэгж, албан хаагч гэсэн байдлаар нарийвчлан судалж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгай төлөвлөгөө боловсруулан, биелэлтийг улирал тутам нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд тайлагнан, мөн иргэдээс гаргасан саналыг байгууллагын үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлсэн байдлыг тайлан, мэдээнд тусгайлан оруулж, байгууллагын цахим хуудаст ил тод, нээлттэй байршуулж хэвшүүлсэн.<br>- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын ERP системд ажиллах байгууллагын нийт албан хаагчдын чадавхийг дээшлүүлэн, системд албан хаагчдыг бүртгэх, мэдээллийг шинэчлэх, засварлах арга хэмжээг тухай бүр шуурхай гүйцэтгэж, албан хаагчдад заавар, зөвлөгөөг тогтмол өгч ажиллаж байна.<br>- Манай байгууллагын өргөдөл, гомдол хариуцсан албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, тухайн албан хаагч ажлаас | 100% | |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td>чөлөөлөгдсөн болон удаан хугацаагаар өвчтэй, чөлөөтэй байх тохиолдолд ажлыг бүрэн хүлээлцүүлж, тасралтгүй, хэвийн үргэлжлэх нөхцөлийг хангаж ажиллаж байна.<br>Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг манай байгууллагын өргөдөл, гомдлын асуудал хариуцсан ажилтан өдөрт нь хүлээн авч, өргөдөл, гомдлын нэгдсэн системд бүртгэн, хянан шийдвэрлэх эрх бүхий этгээдэд өдөрт нь шилжүүлж, өргөдөл, гомдолтой танилцсан албан хаагч уг асуудлыг өөрөө биечлэн хянаж шийдвэрлэхээргүй бол түүнийг хэрхэн судалж шийдвэрлэх талаар удирдлагын тэмдэглэл /цохолт/ бичиж харьяалах албан хаагчид хянан шийдвэрлүүлэхээр өдөрт нь шилжүүлж, удирдлагын цохолттой ирсэн өргөдөл, гомдлыг тухайн албан хаагч өдөрт нь хүлээн авч танилцах, явцын тэмдэглэлийг 10 хоног тутам хөтөлж, хэвшүүлсэн.<br>- Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлээгүй, тайлан мэдээг дээд шатны байгууллагад тайлагнаж ажиллаагүй албан тушаалтанд хариуцлага тооцож, өргөдөл, гомдлын тайлан мэдээнд тусгах, бүх шатны байгууллага, албан тушаалтныг мэдээллээр хангах ажлыг тогтмол зохион байгуулж ажиллахыг холбогдох ажилчдад үүрэг болгосон. 2022 оны байдлаар хуулийн хугацаанд нь шийдвэрлээгүй өргөдөл, гомдол байхгүй байна.</td><td></td><td></td></tr>
<tr><td>20</td><td>4.1</td><td>Нийслэлийн онцгой комиссын хурлын тэмдэглэл, 2022.01.20-ны өдрийн 02 дугаар тэмдэглэл</td><td>Нийслэлийн онцгой комиссын хурлаар Коронавируст халдвар (Ковид-19)-ын нөхцөл байдал, хариу арга хэмжээний талаар авч хэлэлцсэнтэй холбогдуулан гаргасан хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийг хангах зорилгоор манай байгууллагад ажиллаж байгаа бага насны хүүхэдтэй /0-5 насны/ 2 ажилтныг нэг сарын хугацаанд цахимаар ажиллуулж, халдварын эрсдэлээс хамгаалж, үүргийн биелэлт, цахимаар ажилласан албан хаагчдын тоон мэдээллийг өдөр тус бүрээр гарган Нийслэлийн онцгой комиссын Шуурхай штабын nok@ulaanbaatar.mn цахим хаягт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр хүргүүлсэн.</td><td>100%</td><td></td></tr>
<tr><td colspan="6">1.4. Ерөнхийлөгчийн зарлиг</td></tr>
<tr><td colspan="6">1.5. Засгийн газрын тогтоол</td></tr>
<tr><td colspan="6">Хэсгийн дундаж: 100 хувь</td></tr>
<tr><td colspan="6">1.8. Улсын онцгой комиссын хурлын тэмдэглэл</td></tr>
</table>

| |
|---|
| **Хэсгийн дундаж: 100 хувь** |
| 1.11. Нийслэлийн Засаг даргын захирамж |
| **Хэсгийн дундаж: 96 хувь** |
| 1.12. Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэл |
| **Хэсгийн дундаж: 100 хувь** |
| **Нийт дундаж: 99 хувь** |

Байгууллагын нэр: **"УЛААНБААТАР ЛИФТ" НӨҮГ**

## ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
## 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН

2022 оны 12 дугаар сарын 23 Улаанбаатар хот

| | | **Нийт** | Монгол Улсын хууль | УИХ-ын тогтоол, УИХ-ын байнгын хорооны тогтоол | Ерөнхийлөгчийн зарлиг | Улсын онцгой комиссын хурлын тэмдэглэл | Засгийн газрын тогтоол | Ерөнхий сайдын захирамж | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | Засгийн газрын албан даалгавар | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол | Нийслэлийн Засаг даргын захирамж | Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэл | Нийслэлийн онцгой комиссын хурлын тэмдэглэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо | | **20** | - | - | | 2 | 3 | - | - | - | - | 13 | 1 | 1 |
| Хяналтад авсан нийт зүйл заалтын тоо | | **29** | - | - | - | 2 | **4** | - | - | - | - | 15 | 7 | 1 |
| Бүрэн хэрэгжсэн | 100% | **19** | - | - | - | 2 | 3 | - | - | - | - | 12 | 1 | 1 |
| Хэрэгжих шатанд | 70% | **1** | - | - | - | - | - | - | - | - | - | 1 | - | - |
| Хэрэгжилт хангалтгүй | 30% | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Хэрэгжээгүй | 0% | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй /Үнэлэх боломжгүй/ | | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| **Биелэлтийн дундаж** | | **99%** | **-** | **-** | **-** | **100%** | **100 %** | **-** | **-** | **-** | **-** | **96%** | **100%** | **100%** |

ХЯНАСАН:
ДАРГА Д.ГАН-ЭРДЭНЭ

БОЛОВСРУУЛСАН:
ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН Ц.ӨСӨХЖАРГАЛ

Байгууллагын нэр: “УЛААНБААТАР ЛИФТ” НӨҮГ

# ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ДҮН МЭДЭЭНД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 23 Улаанбаатар хот

2022 оны жилийн эцсийн байдлаар тогтоол шийдвэрийн нийт 29 заалтыг хяналтад аван хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийг тус тус хангах зорилгоор үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж, улирал бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнан ажиллаж байна.

1. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор 9 ажил төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжиж байна. Байгууллагад сахилга, дэг журам, дотоод хяналтыг чангатгах, хууль тогтоомж, дүрэм, журмыг чанд сахих, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн (erp.ulaanbaatar.mn цахим хуудас болон цаасаар) өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэж байх, ажилчдын цаг ашиглалтыг хурууны хээний хяналтын системээр байнга бүртгэж, түүнд тавих хяналтыг сайжруулах, ажлын цагийг бүрэн, үр дүнтэй ашиглах, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох зэрэг ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна. Түүнчлэн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн сайжруулж ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар болон галт, хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг хориглосон заалтуудыг нэмж тусган хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд нийт ажилтнуудад дахин танилцуулж, үүрэг даалгавар өгч гарын үсэг зуруулж, баталгаажуулан ажилласан.

2. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 1 дүгээр тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор 1 ажил төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжиж байна. “Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтын түвшинд үндэслэн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг хэрэгжүүлж халдвараас сэргийлэх дэглэмийг сахиж, дархлаажуулалтад нийт ажилтнуудыг хамруулсан.

3. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн “Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 7 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор 2 ажил төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжиж байна. байгууллагын нийт албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээг авч, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлж, байгууллагын өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж хэвшүүлж байна.

4. Улсын онцгой комиссын 01 дүгээр хуралдаанаар Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтын нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээ, төлөвлөгөө, урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах төсвийг авч хэлэлцсэнтэй холбогдуулан

гаргасан хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжсэн байна.

- Халдвар хамгаалал, хорио цээр, хязгаарлалтын дэглэмийг баримтлан, үйл ажиллагаагаа тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж ажилласан. Захирамж, шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд халдвар хамгаалал, хорио цээр, хязгаарлалтын дэглэмийг баримтлан, үйл ажиллагаагаа тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

Ковид-19-ийн тархалтаас урьдчилан сэргийлж, олноор нэг дор бөөгнөрөхгүй байх, хоорондын зай барих зэргээр халдвар хамгааллын дэглэмийг баримтлуулж ажилтан, албан хаагчдыг цахимаар болон зайнаас ажиллуулсан.

Ажилтнуудын гарыг ариутгаж, амны хаалтыг тогтмол хэрэглүүлэн /Ажилтан бүрт 1 удаагийн маск 100 ширхэгийг олгосон. Гар ариутгагч, 1 удаагийн бээлий, ажлын хувцсаар өдөр тутам ханган ажилласан болно./

- Ажлын байранд агааржуулалтыг 2 цаг тутамд, байгууллагын дотор орчинд цэвэрлэгээг, Жавелионы /хлорамин/ уусмалаар байгууллагын өрөөнүүд, хаалганы бариул, ширээ, цонхны тавцанг арчих, ариутгал, халдваргүйжүүлэлтийг өдөр бүр хуваарийн дагуу тогтмол хийж гүйцэтгэсэн.

5. Улсын онцгой комиссын 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаар Коронавируст халдвар (Ковид-19)-ын нөхцөл байдал, хариу арга хэмжээний талаар авч хэлэлцсэнтэй холбогдуулан гаргасан хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийг хангах зорилгоор 1 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжсэн байна.

Манай байгууллагад ажиллаж байгаа бага насны хүүхэдтэй /0-5 насны/ 2 ажилтныг нэг сарын хугацаанд цахимаар ажиллуулж, халдварын эрсдэлээс хамгаалсан.

6. Нийслэлийн Засаг даргын Хотын иргэний жил" болгон зарлах тухай 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор хэрэгжилтийг 2 ажил төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжсэн байна. Дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан. Үүнд:

- Байгууллагын нэгжүүдээс санал авч нэгтгэн 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдөр НЗДТГ-т хүргүүлсэн.

- Иргэдэд цахилгаан шатаар аюулгүй зорчих талаар анхан шатны мэдлэг олгож, сурталчлах эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэрээт лифтүүдийн тоог нэмэгдүүлж орлогоо нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна. 2022 онд "Баян төгөл" СӨХ 1 лифт, "Өргөө 144" СӨХ-ны 3 лифт, "Чандмана" СӨХ-ны 3 лифт, "Чинван" СӨХ-ны 1 лифт, "Гандирс" СӨХ-ны 1 лифт, "Оргил-8" СӨХ-ны 7 лифт, "Арт" СӨХ-ны 3 лифт, "G-108" СӨХ-ны 1 лифт, "Улсын хоёрдугаар төв эмнэлэг"-ийн 2 лифт, "Бэрс 2" СӨХ-ны 4 лифт, нийт 26 лифтэнд шинээр засвар, техник үйлчилгээ хийж гүйцэтгэх ажлын гэрээ байгуулж, 67 ААНБ, СӨХ-дын 360 ширхэг лифтэнд техникийн ээлжит магадлал хийсэн.

7. Нийслэлийн Засаг даргын "Хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх тухай" 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/212 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор 7 ажил төлөвлөсөн бөгөөд 80 хувийн биелэлттэйгээр хэрэгжиж байна. Үүнд:

- Нийслэлийн Засаг даргын "Хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх тухай" 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/212 дугаар захирамжийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдуулан дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд.

- Хөрөнгө оруулалтаар 2021-2022 он дамжин хэрэгжсэн 8 цахилгаан шатны шинэчлэлийн ажил бүрэн хэрэгжиж дууссан бөгөөд улсын комисст хүлээлгэн өгч, цахилгаан шатуудыг байнгын ашиглалтад оруулсан.

Нийслэл, нийслэлийн орон нутгийн сангийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжиж буй нийтийн зориулалттай орон сууцны барилгын 20 цахилгаан шатны шинэчлэлийн ажил

хэрэгжиж байна. Тус 20 цахилгаан шат шинэчлэлийн ажлаас нийтийн зориулалттай орон сууцны барилгын ашиглалтын шаардлага хангахгүй 1 цахилгаан шатыг шинэчлэх ажлын бэлтгэл хангагдсан байна.
Мөн 19 цахилгаан шатны шинэчлэлийн ажлын гүйцэтгэгч байгууллага шалгарсан бөгөөд "Фүшили элеватор" ХХК 4 цахилгаан шат, "Төвхөн трейд" ХХК 5 цахилгаан шат, "Оакс экспресс монголиа" ХХК 10 цахилгаан шатны шинэчлэлийн ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. Ажил гүйцэтгэх гэрээний дагуу тус 19 цахилгаан шатыг БНХАУ-ын үйлдвэрлэгч компани руу захиалга хийгдсэн бөгөөд 2 цахилгаан шатны тээвэрлэлт хийгдэж, 17 цахилгаан шат үйлдвэрлэгдэх шатандаа явж байна.

8. Нийслэлийн Засаг даргын "Эрх шилжүүлэх тухай" 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/209 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор 1 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжсэн байна.

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг захиалагчийн хяналт тавих эрх шилжсэн байгууллагууд хянан баталгаажуулахад холбогдох хууль, журам болон захирамжийн хэрэгжилтийг хангаж ажилласан.

9. Нийслэлийн Засаг даргын "Төсвийн хуваарь батлах тухай" 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/22 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжсэн байна. Үүнд:

- 2022 оны нийслэлийн төсвийн орлогын сар, улирлын хуваарийг батлагдсан, оны эхнээс төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг жигд хангаж, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд гэрээт ААНБ, СӨХ-дын тоог нэмэгдүүлж техник үйлчилгээнээс орох орлогыг өсгөх, техникийн ээлжит магадлалыг өнгөрсөн оныхоос нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна. 2022 онд "Баян төгөл" СӨХ 1 лифт, "Өргөө 144" СӨХ-ны 3 лифт, "Чандмана" СӨХ-ны 3 лифт, "Чинван" СӨХ-ны 1 лифт, "Гандирс" СӨХ-ны 1 лифт, "Оргил-8" СӨХ-ны 7 лифт, "Арт" СӨХ-ны 3 лифт, "G-108" СӨХ-ны 1 лифт, "Улсын хоёрдугаар төв эмнэлэг"-ийн 2 лифт, "Бэрс 2" СӨХ-ны 4 лифт, нийт 26 лифтэнд шинээр засвар, техник үйлчилгээ хийж гүйцэтгэх ажлын гэрээ байгуулж, 67 ААНБ, СӨХ-дын 360 ширхэг лифтэнд техникийн ээлжит магадлал хийсэн

10. Нийслэлийн Засаг даргын "Ажлын хэсэг байгуулах тухай" 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/578 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор 1 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжсэн байна. Үүнд:

- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг үндэслэн байгууллагын даргын 2022 оны 04 дүгээр сарын 29–ний өдрийн А/20 тушаалаар биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийг устгах устгах комисс байгуулан биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийг цуглуулахад үндэслэл болгосон дүрэм, журмыг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуультай нийцүүлэх ажлыг зохион байгуулж, тайлан мэдээг хүргэсэн.

11. Нийслэлийн Засаг даргын "Хуулийн хэрэгжилтийг хангах тухай" 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/828 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжсэн байна.

Үүнд: - Нийслэлийн Засаг даргын "Хуулийн хэрэгжилтийг хангах тухай" 2021 оны А/828 дугаар захирамжийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдуулан Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга, эдгээр

хуулийг дагалдан гарсан хууль тогтоомжийн шинэлэг зохицуулалтыг байгууллагын ажилтнууд болон иргэдэд сурталчлан таниулах, хуулийг дагаж мөрдөх бэлтгэл ажлыг хангах үүднээс 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр сургалт зохион байгуулж ажиллалаа. Мөн байгууллагын цахим хуудаст байршуулан сурталчилж байна.

- Нийслэл хотын дүрэмд оруулах саналаа 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдөр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлсэн болно.

12. Нийслэлийн Засаг даргын “Хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” 2022 оны 05 сарын 16-ны өдрийн А/656, 657 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжсэн байна. Тус захирамжуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдуулан манай байгууллагад тэргүүн дэд, дэд, орлогч дарга ажиллаагүй болно. Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгоогүй бөгөөд орон тоог хэвээр хадгалаагүй болно. Санхүүгийн сахилга батыг мөрдөн ажиллах хүрээнд цахилгааны зардлаас 200,071.41 төгрөг, түлш халаалтын зардлаас 321,726.94 төгрөг, цэвэр бохир усны зардлаас 834,304.30 төгрөгийг тус тус хэмнэсэн. Шуудан холбоо интернэтийн зардлаас 442,088.32 төгрөг хэмнэсэн. Байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулж, батлагдсан цалинг олгосон.

13. “Хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” 2022 оны 06 сарын 09-ний өдрийн А/789 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор 1 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжсэн байна. Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу байгууллагын дарга Д.Ган-Эрдэнийн албан хэрэгцээнд унаж байсан 64-09 УНР улсын дугаартай автомашины мэдээллийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлж, авто баазад хүлээлгэн өгсөн. Үүний үр дүнд тээвэр шатахууны зардлаас 273,645.00 төгрөг, гаражийн түрээсийн зардлаас 224,000.00 төгрөгийг тус тус хэмнэсэн.

14.“Нийслэлийн 2021-2022 оны өвөлжилтийн дүн, 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах тухай” 2022 оны 06 сарын 24-ний өдрийн А/853 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор 5 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжсэн байна. Үүнд:

-Хөрөнгө оруулалтаар 2021-2022 он дамжин хэрэгжсэн 8 цахилгаан шатны шинэчлэлийн ажил бүрэн хэрэгжиж дууссан бөгөөд улсын комисст хүлээлгэн өгч, цахилгаан шатуудыг байнгын ашиглалтад оруулсан.

-Нийслэл, нийслэлийн орон нутгийн сангийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжиж буй нийтийн зориулалттай орон сууцны барилгын 20 цахилгаан шатны шинэчлэлийн ажил хэрэгжиж байна. Тус 20 цахилгаан шат шинэчлэлийн ажлаас нийтийн зориулалттай орон сууцны барилгын ашиглалтын шаардлага хангахгүй 1 цахилгаан шатыг шинэчлэх ажлын бэлтгэл хангагдсан байна.

Мөн 19 цахилгаан шатны шинэчлэлийн ажлын гүйцэтгэгч байгууллага шалгарсан бөгөөд “Фүшили элеватор” ХХК 4 цахилгаан шат, “Төвхөн трейд” ХХК 5 цахилгаан шат, “Оакс экспресс монголиа” ХХК 10 цахилгаан шатны шинэчлэлийн ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. Ажил гүйцэтгэх гэрээний дагуу тус 19 цахилгаан шатыг БНХАУ-ын үйлдвэрлэгч компани руу захиалга хийгдсэн бөгөөд 2 цахилгаан шатны тээвэрлэлт хийгдэж, 17 цахилгаан шат үйлдвэрлэгдэх шатандаа явж байна.

-Хамтран ажилладаг гэрээт 52 ААНБ, СӨХ-дын 146 лифтэнд сар бүр засвар,техник үйлчилгээг хийж өвлийн улиралд хэвийн ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

-Гүүрэн гарцуудад суурилуулсан 8ш цахилгаан шатны засвар, техник үйлчилгээг сар бүр хийж хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажиллаж байна.

-Гэрээгээр хамтран ажилладаг ААНБ, СӨХ-дын хүсэлт болон МХЕГ-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд лифт ашиглагч байгууллагын хүсэлтийн дагуу нийт 67 ААНБ, СӨХ-дын 360 лифтэнд техникийн ээлжит магадлалыг хийж гүйцэтгэсэн.

15. "Журам шинэчлэн батлах тухай" 2022 оны 08 сарын 23-ны өдрийн А/1106 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор 1 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжсэн байна. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх шинэчлэн батлагдсан журмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан.

16. "Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай" 2022 оны 10 сарын 21-ний өдрийн А/1357 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор 1 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжсэн байна. СХД-ийн 34-р хорооны сайжруулсан шахмал түлшийг хэрэглэх заавар зөвлөгөө, сэрэмжлүүлгийг тогтмол өгч, айл өрх бүрийн зуух яндангийн битүүмжлэл, аюулгүй байдлыг хангуулж, түүхий нүүрс хэрэглүүлэхгүй байх чиглэлээр хяналтын үйл ажиллагааг эрчимжүүлэн мэдээг 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн өдөр бүр Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтэст хүргүүлэн ажилласан.

17. "Байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх тухай" 2022 оны 12 сарын 01-ний өдрийн А/1504 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор 1 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжсэн байна.

-2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр манай байгууллагын үр дүнг үнэлж, хангалттай үнэлгээ авсан.

18. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 01 дүгээр хуралдаанаар иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2021 оны жилийн эцсийн тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан гаргасан хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийг хангах зорилгоор 7 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжсэн байна. Манай байгууллагын үйл ажиллагаатай холбоотой чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- 2022 онд иргэдээс манай байгууллага, албан тушаалтанд гаргасан 18 өргөдөл, гомдол, санал хүсэлтийг бүх талаас нь нягтлан судалж, хууль зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэж, хуулийн хугацаанд иргэнд хариу өгч ажилласан.

- Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хийх дүн шинжилгээг сайжруулан, өргөдөл, гомдлын шалтгаан нөхцлийг байгууллагын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн нэгж, албан хаагч гэсэн байдлаар нарийвчлан судалж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгай төлөвлөгөө боловсруулан, биелэлтийг улирал тутам нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд тайлагнан, мөн иргэдээс гаргасан саналыг байгууллагын үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлсэн байдлыг тайлан, мэдээнд тусгайлан оруулж, байгууллагын цахим хуудаст ил тод, нээлттэй байршуулж хэвшүүлсэн.

- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын ERP системд ажиллах байгууллагын нийт албан хаагчдын чадавхийг дээшлүүлэн, системд албан хаагчдыг бүртгэх, мэдээллийг шинэчлэх, засварлах арга хэмжээг тухай бүр шуурхай гүйцэтгэж, албан хаагчдад заавар, зөвлөгөөг тогтмол өгч ажиллаж байна.

- Манай байгууллагын өргөдөл, гомдол хариуцсан албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, тухайн албан хаагч ажлаас чөлөөлөгдсөн болон удаан хугацаагаар өвчтэй, чөлөөтэй байх тохиолдолд ажлыг бүрэн хүлээлцүүлж, тасралтгүй, хэвийн үргэлжлэх нөхцөлийг хангаж ажиллаж байна.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг манай байгууллагын өргөдөл, гомдлын асуудал хариуцсан ажилтан өдөрт нь хүлээн авч, өргөдөл, гомдлын нэгдсэн системд бүртгэн, хянан шийдвэрлэх эрх бүхий этгээдэд өдөрт нь шилжүүлж, өргөдөл, гомдолтой танилцсан албан хаагч уг асуудлыг өөрөө биечлэн хянаж шийдвэрлэхээргүй бол түүнийг хэрхэн судалж шийдвэрлэх талаар удирдлагын тэмдэглэл /цохолт/ бичиж харьяалах албан хаагчид хянан шийдвэрлүүлэхээр өдөрт нь шилжүүлж, удирдлагын цохолттой ирсэн өргөдөл, гомдлыг тухайн албан хаагч өдөрт нь хүлээн авч танилцах, явцын тэмдэглэлийг 10 хоног тутам хөтөлж, хэвшүүлсэн.

- Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлээгүй, тайлан мэдээг дээд шатны байгууллагад тайлагнаж ажиллаагүй албан тушаалтанд хариуцлага тооцож, өргөдөл, гомдлын тайлан мэдээнд тусгах, бүх шатны байгууллага, албан тушаалтныг мэдээллээр хангах ажлыг тогтмол зохион байгуулж ажиллахыг холбогдох ажилчдад үүрэг болгосон. 2022 оны байдлаар хуулийн хугацаанд нь шийдвэрлээгүй өргөдөл, гомдол байхгүй байна.

19. Нийслэлийн онцгой комиссын 02 дугаар хуралдаанаар Нийслэлийн онцгой комиссын хурлаар Коронавируст халдвар (Ковид-19)-ын нөхцөл байдал, хариу арга хэмжээний талаар авч хэлэлцсэнтэй холбогдуулан гаргасан хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийг хангах зорилгоор 1 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжсэн байна. Үүнд:

- Манай байгууллагад ажиллаж байгаа бага насны хүүхэдтэй /0-5 насны/ 2 ажилтныг нэг сарын хугацаанд цахимаар ажиллуулж, халдварын эрсдэлээс хамгаалж, үүргийн биелэлт, цахимаар ажилласан албан хаагчдын тоон мэдээллийг өдөр тус бүрээр гарган Нийслэлийн онцгой комиссын Шуурхай штабын nok@ulaanbaatar.mn цахим хаягт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр хүргүүлсэн.

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН Ц.ӨСӨХЖАРГАЛ